<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>294,172,551.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	47,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,313,851.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	244,811,300.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Их-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Мэдээллийн технологийн аюулгүй байдал, Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудад өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Алтайбаяр, аудитор О.Оюунцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Их-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Их-Уул сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэдний эрэлт хэрэгцээнд тулгуурлан эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан дундаж наслалтыг уртасгана” гэж тодорхойлжээ.

Их-Уул сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн амын эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах, ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлж, эрт илрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх.
- Нийтийн биеийн тамирыг өргөжүүлж, эрүүл чийрэг бие бялдартай, эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт, хэрэгцээнд нийцсэн, чанар, аюулгүй байдлыг хангасан, ил тод, хариуцлагатай, үр дүнтэй, “Үйлчлүүлэгч төв” -тэй эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох “12.7” хувьд өөрчлөлт орж “11.7” хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох “12.5” хувьд өөрчлөлт орж “11.5” хувь болж өөрчлөгдсөн байна.
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268 дугаар тушаалаар баталсан “Ковид-19”-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээг батлах тухай”, 2021 оны А/387/99 дугаар тушаалуудаар батлагдсан “Журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах” шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг эрхлэгчийн зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 12.9 сая төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 863.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Их-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 249.1 сая төгрөгөөр буюу 16.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	1.7	1.6
Дансны авлага	0	85.9	85.9
Бараа материал	49.4	157.3	107.9
Үндсэн хөрөнгө	1,450.9	1504.5	53.6
Биет бус хөрөнгө	41.0	27.2	-13.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,500.3</b>	<b>1749.4</b>	<b>249.1</b>
<b>Эздийн өмч</b>	<b>329.9</b>	<b>329.9</b>	<b>0</b>
- төрийн	329.9	329.9	0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	94.2	94.2	0
Хуримтлагдсан үр дүн	1,076.2	1325.3	249.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн</b>	<b>1,500.3</b>	<b>1749.4</b>	<b>249.1</b>

дүн

Мөнгөн хөрөнгө 1.6 сая төгрөгөөр өссөн байна. Төрийн сангийн хэлтсээс татан төвлөрүүлэлгүй харилцах дандсанд үлдээж баталгаажуулсан байна.

Авлага дансны үлдэгдэл 85.9 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268, А/387/99 дугаар хамтарсан тушаалуудаар батлагдсан “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох” шийдвэрүүдийн дагуу сумын ЭМТ-ийн үзүүлсэн Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үеийн цогц тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн төлбөр 330.7 сая төгрөгийн нэхэмжлэхийг ЭМДЕГ-аас хянаж, 244.8 сая төгрөгийн санхүүжилтийг авч, зөрүү 85.9 сая төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнаснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 107.9 сая төгрөгөөр өссөн нь товлолд болон нэмэлт дархлаажуулалт, Ковид-19-ын эсрэг вакцин, ковид-19 цар тахлын үеийн хамгаалах хэрэгсэл түргэвчилсэн оношлуурын үнэ төлбөргүй орлого 302.4 сая төгрөг, худалдаж авсан 294.9 сая төгрөг, нийт 597.3 сая төгрөгөөр өсөж, үйл ажиллагаанд зарцуулсан 486.1 сая төгрөг, вакциныг устгалын актыг үндэслэн акталсан 3.3 сая төгрөг, нийт 489.3 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 67.5 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Сумын ИТХ-ын 2020 оны 05 дугаар тогтоол төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 72.4 сая төгрөг,
- Иргэн, аж ахуйн нэгжийн хандив 3.8 сая төгрөг,
- ЭМЯ-аас үнэ төлбөргүй 17.7 сая төгрөг,
- Аймгийн ЭМГ-ын даргын 2021 оны А/149 тушаалаар МонПэн санаачилгын хүрээнд ДЭМБ-ын дэмжлэг 4.0 сая төгрөг,
- А/148 дугаар тушаалаар Дэлхийн банкны хөнгөлөлтэй зээлийн хүрээнд 4.8 сая төгрөг,
- Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 111 дүгээр тогтоолуудаар элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон 33.5 сая төгрөг.

Биет хөрөнгө нийт 136.2 сая төгрөгөөр өсөж, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 45, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 111 дугаар, тогтоолоор элэгдлээрээ өртгөө нөхсөн, хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах 67.6 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан болон тайлант хугацааны элэгдлийг зардлын 141.4 сая төгрөгөөс шалтгаалжээ.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 111, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 45 дугаар тогтоолоор элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах 67.6 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, үнийг шинэчлэн тогтоосон 33.5 сая төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэж тайлагнасан байна.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 13.8 сая төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 111 дугаар тогтоолоор цахим эмнэлгийн программ акталсан 15.0 сая төгрөг, тайлант оны элэгдлийн зардлын 0.9 сая төгрөгөөс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 1,325.2 сая төгрөг болж 249.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 249.0 сая төгрөгөөс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 546.1 сая төгрөгөөр буюу 68.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж, бараа материалын зардал, нормативд зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолтын зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардал, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардал байна.

Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 118.0 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 13.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 15.2 сая төгрөг, нормативд зардал 364.7 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 4.4 сая төгрөг, томилолтын зардал 0.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын 7.4 сая

төгрөгийн өсөлт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын 22.3 сая төгрөгийн хэмнэснээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 775.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 61.7 сая төгрөг, ЭМД-ын сангаас 41.7 сая төгрөг, нийт 879.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсөв өөрчлөлтгүйгээр баталсан байна. Энэ нь 2021 онд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 775.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 61.7 сая төгрөг, ЭМД-ын сангаас 41.7 сая төгрөг, нийт 879.2 сая төгрөгөөр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 0.87 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 0.77 сая төгрөгийг улсын төсвөөс, 0.06 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 0.04 сая төгрөгийг ЭМД-ын сангаас санхүүжүүлэхээр сумын ИТХ-аар батлагдсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 0.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 0.06 сая төгрөг, ЭМД-ын сангаас 0.03 сая төгрөг, нийт 0.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 0.9 сая төгрөгийг зарцуулж, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор үндсэн тусламж үйлчилгээ үзүүлэх үйлчилгээг бүрэн үзүүлж чадаагүйгээс ЭМД-аас 0.014 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 0.9 сая төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь цалин түүнтэй адилтгах зардал 0.005 сая төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 0.002 сая төгрөг, нормативд зардал 0.006 сая төгрөг, томилолтын зардал 0.001 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь ЭМД-ын сангийн санхүүжилт 0.065 хувьтай буюу 0.014 сая төгрөгийн төсөв аваагүйтэй холбоотой байна. Энэ нь цалин түүнтэй адилтгах зардал 0.005 сая төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 0.002 сая төгрөг, нормативд зардал 0.006 сая төгрөг, томилолтын зардал 0.002 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын Хүн эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 294,2 сая төгрөгийн дараах нэмэлт орлого орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268, А/387/99 дугаар тушаалуудаар батлагдсан “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох” шийдвэрүүдийн дагуу сумын ЭМТ-ийн үзүүлсэн Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үеийн цогц тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн төлбөр 330.7 сая төгрөгийн нэхэмжлэхийг ЭМДЕГ-аас хянаж, олгосон санхүүжилт 244.8 сая төгрөг.

- “Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн хүрээнд хамтран ажиллах гэрээ”-ний дагуу Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийн санхүүжилт 0.1 сая төгрөг,
- Аймгийн ЭМГ-ын даргын 2021 оны А/40 тушаалаар ЭМГ-аас санхүүжүүлсэн сүрьеэгийн тусламж үйлчилгээг тасралтгүй зохион байгуулах 0.1 сая төгрөг,
- Аймгийн ЭМГ-ын даргын 2021 оны А/41 тушаалаар ЭМГ-аас санхүүжүүлсэн сургалт зохион байгуулах, 0.7 сая төгрөг,
- Аймгийн ЭМГ-ын даргын 2021 оны А/92 тушаалаар ЭМГ-аас санхүүжүүлсэн ковид-19-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад олгох мөнгөн тэтгэмжийн 0.03 сая төгрөг,
- Аймгийн ЭМГ-ын даргын 2021 оны А/114 тушаалаар ЭМГ-аас санхүүжүүлсэн ковид-19-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад олгох мөнгөн тэтгэмж 0.01 сая төгрөг,
- Аймгийн ЭМГ-ын даргын 2021 оны А/24 тушаалаар ЭМГ-аас санхүүжүүлсэн урамшууллын 0.5 сая төгрөг,
- Аймгийн ЭМГ-аас ЭМГ-ын даргын 2021 оны А/120 тушаалаар ЭМГ-аас санхүүжүүлсэн Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооны дэмжлэгтэйгээр сургалт зохион байгуулах 0.1 сая төгрөг,
- Аймгийн ЭМГ-ын даргын 2021 оны А/139 тушаалаар ЭМГ-аас санхүүжүүлсэн ковид-19 халдварын дархлаажуулалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх дэмжлэгт хяналт хийх 0.1 сая төгрөг,
- Аймгийн ЭМГ-ын даргын 2021 оны А/151 тушаалаар ЭМГ-аас санхүүжүүлсэн сүрьеэгийн хавьтлын үзлэг зохиох 0.8 сая төгрөг,

Үүнээс ажиллагсдын цалин хөлс болон нэмэгдэл урамшил 63.5 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 7.9 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 8.0 сая төгрөг, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал 164.8 сая төгрөг, дотоод албан томилолтын зардал 0.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 1.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 0.67 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал 0.047 сая төгрөг, нийт 294.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй дараах онцолсон асуудал байна. Үүнд:

- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268 дугаар тушаалаар баталсан Ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээг батлах тухай”, 2021 оны А/387/99 дугаар тушаалуудаар батлагдсан “Журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах” шийдвэрүүдийн дагуу сумын ЭМТ-ийн үзүүлсэн Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үеийн цогц тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн хүрээнд коронавируст халдвараар хэвтүүлэн эмчилсэн 284 иргэний эмчилгээний төлбөр 275.9 сая төгрөг, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг 135 иргэнд үзүүлсэн эмчилгээ, үйлчилгээний төлбөр 21.6 сая төгрөг, дархлаажуулалтад хамруулсан 6628 иргэний төлбөр 33.1 сая төгрөг, нийт 330.7 сая төгрөгийн эмчилгээ, үйлчилгээ үзүүлж, нэхэмжлэхийг ЭМДЕГ-аас хянаж, 244.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Ковид-19 цар тахалтай үед иргэдээс өгсөн хандивын тоног төхөөрөмж 2.7 сая төгрөг,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны А/116 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх” (Багц-1) ЭМЯ/202101041.2.4 дугаар гэрээний дагуу 14.2 сая төгрөг, 2021 оны А/90 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн анхан шатны тусламж

үйлчилгээнд мобайл технологийг нэвтрүүлэх" хөтөлбөрийн хүрээнд (Багц-1) ЭМЯ/202101042.2.2 дугаар гэрээний дагуу 3.5 сая төгрөг, нийт 17.7 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, -т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 1,849.1 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,849.1 сая төгрөгийн 119 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн ба хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журмыг хэрэгжүүлж ажилласан нь Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268, А/387/99 дугаар тушаалуудаар батлагдсан шийдвэрүүдийн холбогдох заалттай нийцсэн.
- Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.
- Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумдын хүн эмнэлгийг Эрүүл мэндийн төв болгон өөрчилж тус тушаалаар хүчингүй болсон байна. Үүнд: Эрүүл мэндийн сайдын Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2003 оны 114 дугаар тушаал, Сумдын эмнэлгийн статусыг өөрчлөх тухай 2011 оны 292 дугаар тушаал, Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2013 оны 256 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосон. Үүнтэй холбогдуулан ЭМЯ-ны сайдын А/540 тушаалаар сумын Хүн эмнэлгийн зэрэглэл, бусад сумын хүн амыг хамруулан тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим сумын Хүн эмнэлгийн үйлчлэх хүрээг тогтоох, багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулах журам гарсантай холбогдуулан сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилсөн байна. Улсын бүртгэлийн гэрчилгээнд Хөвсгөл

аймгийн Их-Уул сумын хүн эмнэлэг нэртэйгээр үйл ажиллагааг явуулж байгаа нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/540 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн тул аудит хийгдээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Төрийн сангийн хэлтсээс татан төвлөрүүлээгүй харилцах дансны үлдэгдэл 1.6 сая төгрөг,
- Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс Ковид-19 цар тахлын үед иргэдэд үзүүлсэн цогц тусламж үйлчилгээнээс авах авлага 85.9 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангаар аудитаар нийт 2.1 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснийг, аудитын хугацаанд 2.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын тодруулга тайланд хөдөлмөр хамгааллын хэрэглэл бэлтгэсэн 1.2 сая төгрөгийг эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл бэлтгэх зардлаар бүртгэж тайлагнасан болно.
- Зэрэгцүүлсэн мэдээлэл өмнөх тайлант хугацааны дүн нь өмнөх оны санхүүгийн тайлагналын аудитын дүнтэй дүйцэж буй байдлыг хянахад татан төвлөрүүлсэн 0.9 сая төгрөгийг мэдүүлж тайлагнаагүй буюу санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны үйл ажиллагааны үр дүнг 0.9 сая төгрөгөөр өсгөж тайлагнасан.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Мэдээлэл технологийн аюулгүй байдалтай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсвэл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдийн /гүйцэтгэх удирдлага буюу түүнээс эрх олгосон бусад этгээд/ бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж, хэрэгжүүлж ажиллах.

**2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:**

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын хүн эмнэлэг хуучин нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт” оруулах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалын 8 дугаар зүйлийн 8.1-т “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг баримтлана” гэж заасантай нийцэхгүй байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:**

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт”-ийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Их-Уул сумын эрүүл мэндийн төв	4	2.1	2	2.1	-	-	-	-	2	-

/сая төгрөг/

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.